



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/234/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Нарангэрэл
Утас: 261628 Цахим хаяг: narangerelba@audit.gov.mn
Аудитор: Н.Баттөгөлдөр
Утас: 260512 Цахим хаяг: battuguldurn@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа	13
4.2. Албан шаардлага.....	14
4.3 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Э.ТАМИР ТАНАА

2022.02.25 № 07/446
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	43,385,797.00	1,559,937,642.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,637.00	6,100.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	3,637.00	6,100.00
3121	Төгрөг	3,637.00	6,100.00
31213	Арилжааны банк дахь харилцах	3,637.00	6,100.00
33	АВЛАГА	17,042,000.00	1,552,401,600.00
33300	Татаас санхүүжилтийн авлага	17,042,000.00	
336	Зээлийн авлага	-	1,552,401,600.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	-	1,552,401,600.00
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	-	1,552,401,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	26,340,160.00	7,529,942.00
354	Хангамжийн материал	26,340,160.00	7,529,942.00
35410	Бичиг хэргийн материал	11,934,440.00	2,974,565.00
35420	Аж ахуйн материал	277,000.00	217,800.00
35440	Түлш, шатах тослох материал	-	531,032.00
35470	Бусад хангамжийн материал	14,128,720.00	3,806,545.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,597,217,273.72	3,639,676,202.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,597,217,273.72	3,639,676,202.58
392	Биет хөрөнгө	6,513,844,316.18	3,551,857,353.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,558,034,247.00	3,500,167,535.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(494,980,901.52)	(329,825,417.75)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	308,400,000.00	308,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(48,523,333.36)	(79,363,333.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	195,763,587.48	184,934,612.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(48,822,413.64)	(70,791,239.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,239,046.96	39,083,416.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,304,346.69)	(15,476,127.41)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,603,635.00	13,387,934.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,565,205.05)	(6,660,026.89)
39217	Ном	8,000,000.00	8,000,000.00
393	Биет бус хөрөнгө	83,372,957.54	87,818,849.06
39301	Программ хангамж	17,309,090.91	17,309,090.91
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,884,848.48)
39303	Бусад биет бус хөрөнгө	68,532,700.00	77,168,440.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(2,468,833.37)	(3,773,833.37)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,640,603,070.72	5,199,613,844.58
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	4,001,047.18	
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,001,047.18	
413	ӨГЛӨГ	4,001,047.18	
4131	Ажилчидтай холбоотой өглөг	4,001,047.18	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,636,602,023.54	5,199,613,844.58
51	Засгийн газрын хувь оролцоо	6,636,602,023.54	5,199,613,844.58
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,474,849,925.14	1,474,849,925.14
51101	Өмч: - төрийн	1,474,849,925.14	1,474,849,925.14
512	Хуримтлагдсан үр дүн	(45,243,908.54)	1,095,829,839.62
51210	Өмнөх үеийн үр дүн	(45,243,908.54)	2,532,818,018.58
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,436,988,178.96)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,206,996,006.94	2,628,934,079.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,640,603,070.72	5,199,613,844.58

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,116,127,913.81	2,473,792,514.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	163,938,513.81	47,782,214.31
120	Нийтлэг татварын бус орлого	163,938,513.81	47,782,214.31
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,259,351.71	25,740,693.31
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.80	2,463.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /үндсэн хөрөнгө/	100,259,350.91	25,738,230.31
120009	Бусад орлого	6,150,000.00	11,600,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/	57,529,162.10	10,441,521.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	952,189,400.00	2,426,010,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	911,417,400.00	2,418,805,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	911,417,400.00	2,418,805,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,772,000.00	7,205,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	40,772,000.00	7,205,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,279,184,058.10	1,217,228,699.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,279,184,058.10	1,217,228,699.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,172,470,997.24	1,178,681,738.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	445,019,582.55	474,960,271.37
210101	Үндсэн цалин	444,058,291.55	376,351,138.30
210102	Нэмэгдэл	-	61,862,281.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	961,291.00	36,746,851.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,312,975.07	57,727,544.89
210201	Тэтгэврийн даатгал	41,438,639.26	38,952,396.66
210202	Тэтгэмжийн даатгал	4,433,352.48	4,693,787.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,546,681.98	938,757.66
210204	Ажилгүйдлийн даатгал	717,663.67	3,755,029.64
210205	Эрүүл мэндийн даатгал	7,176,637.68	9,387,573.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,521,225.00	44,168,164.39
210301	Гэрэл, цахилгаан	19,373,520.60	15,834,221.28
210302	Түлш, халаалт	16,132,526.69	16,702,254.11
210303	Цэвэр, бохир ус	10,015,177.71	11,631,689.00
2104	Хангамж, бараа материалын зардал	108,838,179.60	74,761,051.20
210401	Бичиг хэрэг	11,206,718.00	10,990,835.00
210402	Тээвэр, шатахуун	9,773,705.00	11,502,423.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,058,180.50	11,908,686.20
210404	Ном хэвлэлийн зардал	3,000,000.00	-
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	9,800,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	64,999,576.10	40,359,107.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,272,100.00	20,588,990.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	99,600.00
210604	Урсгал засвар	7,772,100.00	20,489,390.00
2107	Томилолт, зочны зардал	18,350,000.00	16,472,000.00
210702	Дотоод албан томилолт	18,350,000.00	16,472,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	179,970,841.00	195,106,409.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	169,855,000.00	186,412,736.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	278,130.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	107,591.00	175,543.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,919,150.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	309,186,094.02	294,897,307.21
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	309,186,094.02	294,897,307.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,713,060.86	38,546,960.97
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	106,713,060.86	38,546,960.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	106,713,060.86	38,546,960.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(163,056,144.29)	1,256,563,815.28
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	2,693,551,994.24
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	2,693,551,994.24
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(2,693,551,994.24)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(163,056,144.29)	(1,436,988,178.96)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээр үлдэгдэл	1,474,849,925.14	5,206,996,006.94	113,638,235.75	6,795,484,167.83
2020 оны 12-р сарын 31-нээр үлдэгдэл	1,474,849,925.14	5,206,996,006.94	(45,243,908.54)	6,636,602,023.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,578,061,927.12	2,578,061,927.12
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,474,849,925.14	5,206,996,006.94	2,532,818,018.58	9,214,663,950.66
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	2,578,061,927.12	-	(2,578,061,927.12)
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,436,988,178.96)	(1,436,988,178.96)
2021 оны 12-р сарын 31-нээр үлдэгдэл	1,474,849,925.14	2,628,934,079.82	1,095,829,839.62	5,199,613,844.58

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	956,363,400.80	2,443,054,763.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,174,000.80	2,463.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,174,000.80	2,463.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,174,000.80	2,463.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,174,000.80	2,463.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	952,189,400.00	2,443,052,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	911,417,400.00	2,418,805,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	911,417,400.00	2,418,805,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,772,000.00	24,247,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	40,772,000.00	24,247,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	936,050,020.80	2,437,882,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	936,050,020.80	2,437,882,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	812,294,959.94	846,933,739.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	445,233,284.46	475,206,169.46
210101	Үндсэн цалин	331,531,571.70	376,597,036.64
210102	Нэмэгдэл	78,388,287.74	61,862,280.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,313,425.02	36,746,852.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,557,825.98	61,482,693.98
210201	Тэтгэврийн даатгал	37,674,534.77	42,707,545.75
210202	Тэтгэмжийн даатгал	4,398,371.87	4,693,787.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,345,673.27	938,757.66
210204	Ажилгүйдлийн даатгал	1,243,269.96	3,755,029.64
210205	Эрүүл мэндийн даатгал	6,895,976.11	9,387,573.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,521,225.00	44,168,164.39
210301	Гэрэл, цахилгаан	19,373,520.60	15,834,221.28
210302	Түлш, халаалт	16,132,526.69	16,702,254.11
210303	Цэвэр, бохир ус	10,015,177.71	11,631,689.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,410,773.50	39,492,672.20
210401	Бичиг хэрэг	5,194,910.00	4,304,180.00
210402	Тээвэр, шатахуун	4,989,900.00	5,812,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,058,180.50	10,796,686.20
210404	Ном хэвлэлийн зардал	3,000,000.00	0.00

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	9,800,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,367,783.00	18,579,806.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,272,100.00	20,588,990.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	99,600.00
210604	Урсгал засвар	7,772,100.00	20,489,390.00
2107	Томилолт, зочны зардал	18,350,000.00	14,072,000.00
210702	Дотоод албан томилолт	18,350,000.00	14,072,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	186,949,751.00	191,923,049.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	176,833,910.00	183,229,376.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	278,130.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	107,591.00	175,543.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,919,150.00	240,000.00
212	ТАТААС	00.00	1,552,401,600.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	00.00	1,552,401,600.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	00.00	1,552,401,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	123,755,060.86	38,546,960.97
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	123,755,060.86	38,546,960.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	123,755,060.86	38,546,960.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	20,313,380.00	5,172,463.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	20,318,990.00	5,170,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,318,990.00	5,170,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,318,990.00	5,170,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,318,990.00	5,170,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(20,318,990.00)	(5,170,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(5,610.00)	2,463.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,247.00	3,637.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,637.00	6,100.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,418,805,300.00	2,380,363,339.03	38,441,960.97	98.4
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,418,805,300.00	2,380,363,339.03	38,441,960.97	98.4
210	Бараа, үйлчилгээний зардал	866,403,700.00	827,961,739.03	38,441,960.97	95.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	489,786,800.00	475,206,169.46	14,580,630.54	97.0
210101	Үндсэн цалин	362,840,800.00	376,597,036.64	(13,756,236.64)	103.8
210102	Нэмэгдэл	98,648,500.00	61,862,280.59	36,786,219.41	62.7
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	28,297,500.00	36,746,852.23	(8,449,352.23)	129.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,121,200.00	61,482,693.98	4,638,506.02	93.0
210201	Тэтгэврийн даатгал	46,529,700.00	42,707,545.75	3,822,154.25	91.8
210202	Тэтгэмжийн даатгал	4,897,900.00	4,693,787.31	204,112.69	95.8
210203	ҮОМШӨ ний даатгал	3,918,300.00	938,757.66	2,979,542.34	24.0
210204	Ажилгүйдлийн даатгал	979,600.00	3,755,029.64	(2,775,429.64)	383.3
210205	Эрүүл мэндийн даатгал	9,795,700.00	9,387,573.62	408,126.38	95.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,591,200.00	44,168,164.39	10,423,035.61	80.9
210301	Гэрэл цахилгаан	18,362,600.00	15,834,221.28	2,528,378.72	86.2
210302	Түлш, халаалт	24,146,400.00	16,702,254.11	7,444,145.89	69.2
210303	Цэвэр, бохир ус	12,082,200.00	11,631,689.00	450,511.00	96.3
2104	Хангамж, бараа материалын зардал	43,569,100.00	39,492,672.20	4,076,427.80	90.6
210401	Бичиг хэрэг	4,738,000.00	4,304,180.00	433,820.00	90.8
210402	Тээвэр (шатахуун)	8,674,800.00	5,812,000.00	2,862,800.00	67.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	11,566,200.00	10,796,686.20	769,513.80	93.4

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	18,590,100.00	18,579,806.00	10,294.00	99.9
2106	Эд хогшил худалдан авах	21,135,900.00	20,588,990.00	546,910.00	97.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	500,000.00	99,600.00	400,400.00	19.9
210604	Урсгал засвар	20,635,900.00	20,489,390.00	146,510.00	99.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	191,199,500.00	187,023,049.00	4,176,451.00	97.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	181,457,500.00	178,329,376.00	3,128,124.00	98.3
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	8,000,000.00	8,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	375,300.00	278,130.00	97,170.00	74.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	255,700.00	175,543.00	80,157.00	68.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	121,000.00	-	121,000.00	-
210806	Мэдээллийн технологийн зардал	990,000.00	240,000.00	750,000.00	24.2
212	ТАТААС	1,552,401,600.00	1,552,401,600.00	-	100.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,552,401,600.00	1,552,401,600.00	-	100.0
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	1,552,401,600.00	1,552,401,600.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,419,205,300.00	2,380,365,802.03	38,839,497.97	98.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,419,205,300.00	2,380,363,339.03	38,841,960.97	98.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,419,205,300.00	2,380,363,339.03	38,841,960.97	98.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	2,463.00	(2,463.00)	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,463.00	(2,463.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,637.00	(3,637.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,100.00	(6,100.00)	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	35.00	35.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	6.00	6.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	24,247,000.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	24,247,000.00
210	Бараа, үйлчилгээний зардал	-	24,142,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	14,072,000.00
210702	Дотоод албан томилолт	-	14,072,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	10,070,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	10,070,000.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	105,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	105,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	105,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	24,247,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	24,247,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	24,247,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийг дуусталх хугацаанд ахлах аудитор Б.Нарангэрэл, аудитор Н.Баттөгөлдөр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Сэржмядаг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/36 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын эрхэм зорилго нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжил, хамгааллын талаарх Засгийн газрын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах, бие даан хөгжих чадварыг эзэмшүүлэх замаар амьдралын чанарыг нь дээшлүүлэхэд оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:

- Монгол Улсын хууль тогтоомж болон Олон улсын гэрээ, конвенцыг дагаж мөрдүүлэхийн тулд хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар төрөөс баримталж буй бодлогыг салбарын бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг хангах, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх,
- Мэдээлэл харилцаа холбоо, технологид нэвтрэхэд үүсэх саад бэрхшээлийг арилгах замаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн оролцоог дэмжих, хүртээмжтэй орчныг бий болгох явдал юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээний газар нь 2021 оны санхүүгийн тайланд дотоод аудитын хяналт шалгалтыг зохион байгуулах ажлын удирдамж, төлөвлөгөө боловсруулан батлуулж Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын үйл ажиллагаанд санхүүгийн болон дотоод хяналт шалгалтыг тайлант онд 6 чиглэлээр хяналт шалгалтыг хэрэгжүүлж, чиглэл тус бүрээр зохих дүгнэлт, зөвлөмж өгч, хэрэгжилтийг хянаж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувь 12,791.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,440,989,1 мянган төгрөгөөр буюу 21.7 хувиар буурч материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материалын дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3.6	6.1	2.5
Авлага	17,042.0	1,552,401.6	1,535,359.6
Бараа материал	26,340.1	7,529.9	(18,810.2)
Үндсэн хөрөнгө	6,597,217.3	3,639,676.2	(2,957,541.1)
Нийт хөрөнгө	6,640,603.0	5,199,613.8	(1,440,989.1)
Өр төлбөр	4,001.0	-	(4,001.0)
Хуримтлагдсан үр дүн	6,636,602.0	5,199,613.8	(1,436,988.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,640,603.0	5,199,613.8	(1,440,989.1)

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс өмнөх оны үлдэгдлээс 2,5 мянган төгрөгөөр өссөн нь арилжааны банкин дах харилцах дансны үлдэгдэл нөлөөлсөн;
- Авлагын данс нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 88 дугаар тогтоолоор протезийн үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон санхүүжилтийн 1,535,359.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Бараа материалын дансны эхний үлдэгдлээс НҮБ-ийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан хандиваар ариун цэврийн хэрэгслийг тарааж 18,810.2 мянган төгрөгөөр буурсан;
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл нь ТӨБЗГ-ын:
 - 460 дугаар тогтоолоор 2,691,290.4 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 1 дүгээр байрны барилга;
 - 525 дугаар тогтоолоор 39,370.3 мянган төгрөгийн анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг тус тус актлагдсан;
 - 09 дугаар тэмдэглэлээр 51,643.9 мянган төгрөгийн хашаа байшин Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын балансаас баланст шилжиж ирсэн зэргээс шалтгаалж 2,957.5 мянган төгрөгөөр буурсан;
- Өр төлбөр данс нь НДШ-ийн 3,755.1 мянган төгрөг, ХХОАТ-ын 245.9 мянган төгрөгийн өглөгийг барагдуулсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны урсгал санхүүжилтийг 1,526,084.3 мянган төгрөгөөр төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас урсгал зардлыг 617,185.5 мянган төгрөгөөр бууруулан, хувийн хэвшилд олгох татаас санхүүжилтийг 1,552,401,6 мянган төгрөгөөр нэмж, санхүүжилтийг 2,461,300.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор бараа үйлчилгээний зардлыг 42,495.1 мянган төгрөгөөр бууруулж, 2,418,805.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 1,526,084.3 мянган төгрөгийг баталжээ. Гүйцэтгэлээр урсгал зардалд 866,403.7 мянган төгрөг, хувийн хэвшилд олгох татаас 1,552,401,6 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн хүлээн авч 98.4 хувийг зарцуулан 38,442.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,380,363.3 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшил зардлыг 14,580.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 4,638.5 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардлыг 10,423.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 4,076.4 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардлыг 546.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 4,176.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэл Т
	Код	Нэр				
1	72206		2,418,805.3	2,380,363.3	38,442.0	98.4
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	866,403.7	827,961.7	38,441.9	98.4
1.2	80404	Хувийн хэвшилд олгох татаас	1,552,401.6	1,552,401.6	0.0	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт, түүнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 98.4 хувийн биелэлттэй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд анхаарал татсан асуудал байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 88 дугаар тогтоолоор протезийн үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор эргэн төлөгдөх нөхцөлөөр 1,552,401.6 мянган төгрөгийн санхүүжилт баталсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 18 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд худалдан авалтын 4, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 6, зарлагын 62,673,315.00 төгрөгийн 8, шийдвэр гаргах авлагын 1 гүйлгээг мэдээллийг хугацаа хоцроосон;

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа

албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 акт, 2 албан шаардлага, 1 зөвлөмжийн 98.3 хувийн биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, Үндэсний аудитын газарт 2021 онд 1/89 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	500.0	1	500.0	-	-	100.0
Албан шаардлага	2	7,200.0	2	7,200.0	-	-	95.0
Зөвлөмж	1	5,834.0	1	5,834.0	-	-	100.0
Нийт дүн	4	13,534.0	3	13,534.0	1	-	98.3

Өмнөх аудитаар и баримтын албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлсэн, шилэн дансны мэдээлэл хоцроосон албан шаардлагыг 90 хувь биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 88 дугаар тогтоолоор Дэл оюу дөл ХХК-д протезийн үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгосон санхүүжилтийн эргэн төлөлтийг анхаарах шаардлагатай гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,976,565.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,968,111.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,144.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 7,309.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 8,453.8 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж баталгаажуулав. Үүнд:

Тайлант онд үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилгыг акталсантай холбоотой хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд бууруулсан 2,578,061.9 мянган төгрөг;

Санхүүгийн байдлын тайланд акталсан барилгын хуримтлагдсан элэгдлийг нэмэх үлдэгдэлтэй илэрхийлсэн 2,361,465.0 мянган төгрөг;

Биет бус хөрөнгөнд бүртгэвэл зохих 8,635.7 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг биет хөрөнгийн "газар" дансанд бүртгэсэн;

Үнэ төлбөргүй шилжиж ирсэн 8,349.0 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авснаар илэрхийлсэн;

Санхүүгийн үр дүнгийн тайланд 11,600.0 мянган төгрөгийн тендерийн орлогыг тусгаагүй алдааг залруулсан.

4.2. Албан шаардлага

Сагсан бөмбөгийн эрэгтэй, эмэгтэй тамирчдын 1,144.0 мянган төгрөгийн өмсгөл худалдан авч төсвийг үр ашиггүй зарцуулсан.

Энэ нь “Төсвийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйл 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг хэмнэлттэй, батлагдсан зориулалтын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх

4.3 Зөвлөмж

1. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн ашгийг хамгаалахад төрөөс баримтлах бодлогыг таниулах, сурталчлах, хуулийн хэрэгжилтийг хангах, төр болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах чиглэлээр 2021 онд зохион байгуулагдсан сургалтын зардлын 7,309.8 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7 Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлд анхан шатны баримттай ажил гүйлгээг бүртгэж, зөрчлийг давтан гаргахгүй, таслан зогсоох зөвлөмжийг өгөв.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр, код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн											
				Үүнээс											
				Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж			
Т	О	Т	О	Т	О	Т	О	Т	О	Т	О	Т	О		
Дүн		Дүн		Дүн		дүн		дүн		дүн		дүн			
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар															
1	ХБХХЕГ АХГ-2022/234/НА-СТАТШЗ	Тайлант онд үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилгыг акталсантай холбоотой хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд бууруулсан бичилт хийгээгүй	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хийсэн хөрөнгийн дахин үнэлгээний үр дүн болон хөрөнгийн үнэлгээний залруулгыг холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу дансанд бүртгэх.	1	2,578,061.9	1	2,578,061.9								
2	ХБХХЕГ АХГ-2022/234/НА-СТАТШЗ	Санхүүгийн байдлын тайланд акталсан барилгын хуримтлагдсан элэгдлийг нэмэх үлдэгдэлтэй илэрхийлсэн.	Элэгдлийг НББОУС-ын дагуу тооцоолж бүртгэх	1	2,361,465.0	1	2,361,465.0								
3	ХБХХЕГ АХГ-2022/234/НА-СТАТШЗ	Биет бус хөрөнгөнд бүртгэвэл зохих газар эзэмших эрхийг биет хөрөнгийн "газар" дансанд бүртгэсэн	НББОУС-ын дагуу тооцоолж бүртгэх	1	8,635.7	1	8,635.7								
4	ХБХХЕГ АХГ-2022/234/НА-СТАТШЗ	Үнэ төлбөргүй шилжиж ирсэн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авснаар илэрхийлсэн	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл; 5.1. Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтлан ажиллах.	1	8,349.0	1	8,349.0								

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

5	ХБХХЕГ АХГ- 2022/234/ НА- СТАТШЗ	Санхүүгийн үр дүнгийн тайланд тендерийн орлогыг тусгаагүй	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл; 5.1. Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтлан ажиллах.	1	11,600.0	1	11,600.0												
6	ХБХХЕГ АХГ- 2022/234/ НА- СТАТШЗ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн ашгийг хамгаалахад төрөөс баримтлах бодлогыг таниулах, сурталчлах, хуулийн хэрэгжилтийг хангах, чиглэлээр 2021 оны 09 дүгээр сарын 21-ны өдөр зохион байгуулагдсан сургалтын томилолтын зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтыг мөрдөж ажиллах	1	7,309.8													1	7,309.8
7	ХБХХЕГ АХГ- 2022/234/ НА- СТАТШЗ	Сагсан бөмбөгийн эрэгтэй, эмэгтэй тамирчдын өмсгөл худалдан авч төсвийг үрэлгэн зарцуулсан.	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол 1.4. энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах	1	1,144.0					1	1,144.0								
Дүн				7	4,976,565.4	5	4,968,111.6			1	1,144.0							1	7,309.8
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																			
1	ХБХХЕГ АХГ- 2022/234/ НА- СТАТШЗ	Шилэн дансны цахим хуудсанд өмнөх оны аудитын дүгнэлт тайлан, худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэлийн 3 мэдээг хугацаа хоцроон оруулсан байна	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг арилгах	1	0													1	0
Дүн				1														1	
Нийт дүн				8	4,976,565.4	5	4,968,111.6			1	1,144.0	1						1	7,309.8



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 215/А0160459

АХГ-2022/234/НА-СТА-023

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.1-ийн дагуу хийсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд худалдан авалтын 4, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 6, зарлагын 62,673,315.00 төгрөгийн 8, шийдвэр гаргах авлагын 1 гүйлгээг мэдээллийг хугацаа хоцроосон;

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг; 6.4.5. "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," заалтад ницэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын нягтлан бодогч Ж.Хаш Эрдэнэд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Тамир нягтлан бодогч Ж.Хаш-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

(Handwritten signatures)

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Б.НАРАНГЭРЭЛ
Н.БАТТӨГӨЛДӨР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 216/АД/2022

Улаанбаатар хот

АХГ-2022/234/МА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-ийн дагуу хийсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сагсан бөмбөгийн эрэгтэй, эмэгтэй тамирчдын 1,144,000.00 төгрөгийн өмсгөл худалдан авч төсвийг үр ашиггүй зарцуулсан;


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйл 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;" заалтад нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4 "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Тамир, нягтлан бодогч Ж.Хаш-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Б.НАРАНГЭРЭЛ
Н.БАТТӨГӨЛДӨР

